



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/29 АУА-2018/30/СТА-ОИТС Мандалговь хот

Г

Зөрчлийг арилгуулах тухай

Г

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 13.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Баянжаргалан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад 9,772,360.00 /Есөн сая долоон зуун далан хоёр мянга гурван зуун жар/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дахь 200,000.00 төгрөгийн өр төлбөр, 4,487,360.00 төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах;/ заасныг;

2. Сангийн хөрөнгөөс 5,085,000.00 төгрөгийг сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто машины урсгал засвар хийх” зардалд зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно/, 60.3.1.-д /орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 7 дугаар зүйлийн 7.4.7.г/-д /Сумын эмнэлэг, лаборатори, эрчүүдийн амрах байрны засвар үйлчилгээ, тохжилт, тоног төхөөрөмж/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын

байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн;/, 4.1.4-т /Байгууллага иргэдтэй үүссэн материаллаг буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Харилцагч байгууллага, хувь хүмүүстэй авлага, өр төлбөрийн тооцоог нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, барагдуулах ажлыг зохион байгуулах;

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2018 онд Төсвийн тухай хуулийн шаардлагыг хангаагүй, зориулалтын бус зардалд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг жагсаалтаас хасч тодотгох,

Авлага, өр төлбөртэй холбоотой зөрчлийг 2018 оны 03 дугаар сарын 01-ний дотор, зориулалт бус зарцуулалттай холбоотой зөрчлийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор арилгаж албан шаардлагын биелэлтийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Баянжаргалан сумын Засаг дарга Г.Туяа, нягтлан бодогч Ц.Наранжаргал нарт хариуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

<p><b>ӨГСӨН:</b></p> <p>АХЛАХ АУДИТОР <i>Д.ИХБАЯР</i></p> <p>4817144213 3ЮА0039 9033475</p>	<p><b>ЗӨВШӨӨРСӨН:</b></p> <p>ЗАСАГ ДАРГА <i>Г.ТУЯА</i></p> <p>НЯГТЛАН БОДОГЧ <i>Ц.НАРАНЖАРГАЛ</i></p>
---	---

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.